

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХИ ХУУЛЬ ЗҮЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2018 оны 06 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, Л.Мөнхбаатар, Б.Дэлгэрсайхан нараас 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдуулсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 12 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ц.Гарамжав, Д.Ганболд, Х.Нямбаатар, Н.Учрал болон холбогдох бусад албан тушаалтнууд орж ажиллаж байна.

Хууль зүйн байнгын хороо 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, уг төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүлээлгэх ялын бодлогыг хэт сулруулах зохицуулалтыг төслөөс хасаж, тодорхой хязгаарлалтыг тусгах нь зүйтэй гэсэн саналыг хэлэлцэж, дэмжсэн болно.

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаархи тус Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг нэгтгэн томьёолж Та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаархи Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ш.РАДНААСЭД

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАЛААРХИ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1. Төслийн 1, 2 дугаар зүйлийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Хүнд” гэснийг “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жил, түүнээс дээш хугацаагаар тогтоосон” гэж, 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хөнгөн” гэснийг “энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй” гэж, 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хөнгөн” гэснийг “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй” гэж тус тус өөрчилсүгэй.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь, Ц.Гарамжав,
Д.Ганболд, Х.Нямбаатар, Н.Учрал /цаашид “Ажлын хэсэг” гэх/**

2. Төслийн доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйлийг хасах:

“3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

Хууль зүйн байнгын хороо